

салбарт ч зонхилох магадлалтай. Европчуудын хэрэглээ багасахгүй нь мэдээж, гэвч Европ бол нийлбэр утгаараа «Дэлхийн хамгийн том музей» болох юм.

Энэ их зорилтыг хэрэгжүүлэхийн тулд БНХАУ дангаараа хүчин зүтгэхгүй нь дээр тодорхой байна. Гэхдээ Тайванийг зэвсгийн хүчээр чөлөөлөх мэтийн адал балмад санаархлаасаа эргэлтгүй татгалзаж, тэр арлын статус-квог бүрэн хүлээн зөвшөөрснөөр валют санхүүгийн асар их боломжтой болно. Гонконг, Макаог удахгүй нэгтгэх боловч тэнд дарангуйлал хэрэгжүүлэх бүх хувилбараас бас татгалзах ёстой. Тайваньтай эдийн засгийн гүнзгий интеграцид орж, бүсийн хэмжээний эдийн засгийн томхон бүтэц /АНУ, Канад, Австралийг үл оролцуулан бий болговол тэртээ тэргүй XXI зуун аяндаа Хятадынх болно гэж гадны судлаачид үздэг юм билээ.

Холбогдох ном хэвлэл

- 1.О.Нямдаваа. XXI зуун ба Ази, Номхон далайн орнууд, «Дорно-Өрнө» сэтгүүл, 1994 № 1(34)
- 2.Д.Баярхүү.Олон улсын харилцааны систем ба Монгол Улсын тусгаар тогтнолын асуудал, «Засгийн газрын мэдээ» 1996.09.05 № 170 (610)
- 3.Өмнөд хөршөөр, «Стратеги судлал» сэтгүүлийн тусгай дугаар 1995 №2
- 4.Я.Накасонэ, Я.Мураками, С.Сато, С.Нисибэ.После «Холодной войне» (Совместное исследование) Москва, «Прогресс», «Универс», 1993
- 5.Dan Gallin. Inside the New World Order: Drawing the Battle Lines, New Politics, Vol.V, №1, Summer 1994
6. Richard Baum. Political Stability in Post-Deng Cnina, Asian survey, Vol, XXXII, №6 June 1992

АЗИЙН ЧИГЛЭЛИЙН УРТ ЗАМД

Д.Эрдэмбилэг*

XXI зуун бол Азийн эрин зуун болно гэж үздэг. Энэ зөн билэг. Азийн зүрхэнд орших нутаг уудам, хүн ам цөөн, хөгжил буурай, далайд гарцгүй, эх газрын дөрвөн улирлын эрс тэс уур амьсгалтай Монгол орны хувьд ээл ивээлтэй байх болтугай.

Төв Азийн Алтай, Саян, Хэнтий Хангайн уул нуруудын үр шимт хөндий, дорнодын тэгш тал, өмнөдийн их говиор нүүдэллэн

* Элчин сайд ахмад дипломатч.

нутагладаг монголчууд энэ ХХ зуунтай золгож улмаар манжийн дарлалаас ангижран улс орноо туурга тусгаар, бүрэн эрхтэй болгож энэ уудам тивийн улс гүрэнтэй сайн хөршийн хэлхээ холбоо тогтоож хөгжин мандах хүсэл эрмэлзэлтэй байжээ. Гэвч гадна дотнын элдэв саад тотгортой тулгарч үндэсний эрх ашиг нь их бага хэмжээгээр хохирсоор байжээ.

Монгол улсын газар зүйн өвөрмөц байршил их нөлөө үзүүлсээр ирснийг үгүйсгэх аргагүй. Мөнх цаст уул нуруудаас эх авсан бараг бүх гол мөрөн нь төрөлх нутгаа орхиж харийн усан савыг тэтгэдэг атлаа усан замаар тээх, холбох тэнхэл даан ч үгүй байжээ. Эрт дээр цагаас уламжилсан морин өртөө, тэмээн жингийн цуваанаас өөр орчин цагийн зам, тээвэр, харилцаа холбооны сүлжээ гэж байсангүй. Аялан жуулчлах, судлан шинжлэх гэсэн эрдэмтэд, манай газар нутгийн баялаг, малын түүхий эдийг тонох гэсэн гадаадын олон цөөн худалдаачин-торгоов, олз хайгчдаас өөр Монгол орныг мэдэх алс холын гадаадынхан бараг үгүй байв. Монголчууд өөрсдийнхөө тухай гадаад ертөнцөд мэдээ хүргэх тэнхээгүй, нутаг хушуундаа залбиран суух нь хоёр их гүрний хооронд хавчуулагдсан бөгөөд тив дэлхийн улс орноос тасархай орших тэр үеийн Монгол орны зовиуртай дүр төрхийг илтгэн илэрхийлж байжээ.

Оросын хаант засаг, Гоминданы Хятадын эрх баригчдын Монгол улсыг эрхшээлдээ авч хуйвалдах, гадаад ертөнцөөс ингээд тусгаарлан хавчих бодлого явуулсаар байв. 1921 оны ардын хувьсгал ялж, улмаар Бүгд Найрамдах Монгол Ард Улс бүрэлдэн тогтох үед Зөвлөлт Орос Улсаас өөр харж хандах улс гүрэн Ази тивд ч байсангүй. Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааны олон жилийн түүхэн туршлага, эдүгээгийн Монгол улсын бодит байдал бас л нэгийг өгүүлнэ.

Их дайны дараах хоёр туйлт дэлхий ертөнцөд Монгол улсын эзэлж байсан байр суурь тодорхой байв. Европ тивд Өрнөд Дорнодын цэргийн хоёр том эвсэл халз тулан зогсож, асар хөнөөлт зэвсгээр улайран хөөцөлдөж байжээ. Тэр үед хуучин ЗХУ тэргүүтэй социалист лагерийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг гэж тооцогдож байсан Монгол улс тэрхүү улс төр, эдийн засгийн эвсэл холбоонд хамтран зүтгэж, Европын дорнод хэсгийн зүг рүү гадаад дотоод бодлогоо гуйвалтгүй чиглүүлж, нийтийн нэгтгэн зохицуулсан бодлого, үйл ажиллагаа явуулахад нь мөр зэрэгцэн алхалж, хүч хавсран явжээ.

Колонийн дарлалд олон жил талхигдан хоосорсон, дайны дараа өрнөдийн хүчирхэг орнуудын нөлөөнд орсон, дэлхийд хүн амаар их давуу, хөгжлийн түвшингээр адилгүй, шашин шүтлэг

өвөрмөц байсан Ази тивийн улс орны зүг рүү хандах Монголын гадаад бодлогын үзэл баримтлал гэж бараг байсангүй.

Өмнөд хөрш маань «уулын оргилд тухлан сууж хоёр барын нанчилдааныг ханатлаа үзэх» гэсэн бодлоготой байсан үе. Хуваагдмал Солонгос, Вьетнам хоёр үзэл бодлого, дайн тулалдааны талбар болж байв.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд идэвхтэй оролцож байсан Энэтхэг, Индонез, Бирмийн Холбоо, Шри Ланка, Балба улстай Монгол улс 50-60-аад онд дипломат харилцаа тогтоож, дараа нь арабын зарим улс оронтой найрсаг харилцаа тогтоосон билээ. Гэтэл аливаа зам харилцаагүй алс хол газрын мухарт орших улс оронтой сайн хөршийн хэлхээ барилдлага, идэвхтэй харилцаа барих боломж, арга зам хомс байв.

Монгол улс НҮБ-ын гишүүн болов. Өрнөдийн их гүрнүүдтэй дипломат харилцаа тогтоож, АНУ-тай харилцаа тогтоох асуудлаар хэлэлцэж эхлэв. Иран, Малайзи, Япон, Филиппин, Тайланд зэрэг Азийн улс оронтой хэвийн харилцаатай болов. Ийнхүү 1970-аад онд дэлхийн зуу орчим оронтой дипломат харилцаатай болсон Монгол улс гадаад бодлогынхоо үзэл баримтлалд Азийн чиг шугамыг тодорхойлох болсон билээ.

Олон улсын түгшүүртэй байдал харьцангуй намжих төлөвтэй болж, Өрнөд Дорнодын харилцаанд нааштай үйл явц эхэлсэн үед манай төр засгийн дээд хэмжээний төлөөлөгчдийг Азийн зарим улс оронд айлчлуулах, мөн парламент болон олон нийтийн байгууллагын төлөөлөгчдийг илгээх зэрэг бусад арга хэмжээ хэрэгжүүлж ирсэн нь Монгол улсын гадаад харилцааг идэвхжүүлэхийн чухал түлхэц болжээ.

Энэ зорилгын үүднээс манай Гадаад явдлын яамны шугамаар Монгол улсын сайн санааны төлөөлөгчдийг Азийн зарим улсад илгээж, тус бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааг тогтоон өргөжүүлэх асуудлаар хоёр талын санал бодлыг солилцох, улс орныхоо байдлыг харилцан мэдээлэх, олон улсын асуудлаар байр сууриа тандаж судлах талаар анхны алхам хийж, улмаар үр ашиг олох хандлагатай болсныг тэмдэглүүштэй.

1970-аад оноос эхлэн Гадаад явдлын Яамны үйл ажиллагааны жил жилийн үндсэн чиглэлд Азийн улс оронд Монгол улсын сайн санааны төлөөлөгчдийг айлчлуулах арга хэмжээг төлөвлөн тусгаж эхэлсэн юм. Тус яамны Азийн асуудлыг эрхэлсэн орлогч сайд тэргүүтэй төлөөлөгчид 1973 оны хоёрдугаар сард Индонези,

Сингапур, Малайзид айлчилсан нь тэрхүү арга хэмжээний эхлэл болжээ. Монгол улсын сайн санааны энэ анхны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Б.Ванчиндорж, З.Эрэндоо бид гурав оролцсон.

Манай төлөөлөгчдийг Жакартад хүрэлцэн очиход ГЯЯ-ны сайд Адам Малик хүлээн авч уулзан элэгсэг дотно ярилцсан юм. Бид Индонезийн ГЯЯ-ны улс төрийн асуудал эрхэлсэн ерөнхий захирал Диди Жаядининград тэргүүтэй төлөөлөгчидтэй найрсаг яриа хэлэлцээ хийж, хоёр талын сонирхол татсан олон асуудлаар саналаа солилцсон. Манай хоёр улс хоорондоо алив замын харилцаагүй, бие биенээс алс хол оршдог болохоор арилжаа явуулахад асар бэрхшээлтэй авч соёлын салбарт харилцаатай байх боломжтой юм гэдгийг хоёр тал тэмдэглэж байлаа.

Бандунгийн бага хурлыг хуралдуулах санаачилга гаргасан орны нэгэн болох Индонези улс Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, эдийн засаг, нийгмийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд хүчин чармайж байгаа болон АСЕАН-д гүйцэтгэж буй үйл ажиллагааныхаа тухай тэд дэлгэрэнгүй ярьж билээ.

Азийн аюулгүй байдлын системийн тухай асуудлаар Индонезийн бодол санаа илэрхий байв. Хэрэв ийм систем тогтооё гэвэл тус тив нутгийн бүх улс оролцох ёстой. Эс тэгвэл амжилтад хүрэхгүй гэж үздэг ажээ. Зүүн өмнөд Азид төвийг сахисан бүс бий болгох асуудлаар гэвэл энэ бүс нутагт олон жилийн туршид дайны гал дүрэлзэж, үй олон хүний амь насыг хөнөөж, эд агуурсыг сүйтгэсэн аюулт голомтыг таслах нэгэн зам болж болох юм гэж үзэж байгаа нь ойлгогдож билээ. Энэ бүс нутгийн улс орнуудын эдийн засаг, нийгмийн асуудлуудыг нааштай шийдвэрлэхэд АСЕАН-ы үүргийг өргөжүүлэхийн чухлыг тэмдэглэн ярьж байлаа. Тэр үед Вьетнам, Лаос зэрэг орон энэ холбоонд ороогүй үе байсан нь цаанаа бас учир шалтгаантай байсан юм.

Ер нь манай яамны төлөөлөгчид сайдын гарын үсэгтэй төвийн удирдамжийг чанд баримтлан албан ёсны яриа хэлэлцээ хийдэг дэг дүрэмтэй байсан болохоор хувийн бодол санааг илэрхийлэх эрхгүй байжээ. Бас тэгээд Монгол улс тэр үед Варшавын Гэрээний болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын зүгээс олон улсын чухал асуудлаар нэгтгэн зохицуулсан бодлогыг хэрэгжүүлэхэд хамтран зүтгэх үүрэг хариуцлагатай байсныг мартаж болохгүй үе байжээ. Монгол улсыг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай асуудлыг сэдэж санаачлах аргагүй байв.

Индонезийн албаны хүмүүс биднээс Монгол-Хятадын харилцааны тухай сонирхон асууж байлаа. Мөн Индонезийн

коммунист намынхан нэгэн их гүрний далд түлхээсээр төрийн эсрэг хуйвалдаан хийх гэсэн оролдлогыг хүчээр дарсан тухай ярьж байсан нь бидний бодол санааг тандан мэдэх гэсэн болов уу.

Индонезийн тал тусгай жижиг нисэх онгоцоор биднийг ява арлын Энэтхэгийн далайн эрэг дэх нэгэн хотонд хүргэж амралтын өдрийг тэнд өнгөрүүлэв. Наран эгц дээрээс ээх бөгөөд наранд цохиулж түлэгдэхээс болгоомжил, «далайн чоно, загас аюултай!» гэж сэрэмжлүүлсэн хаалт дээснээс цааш сэлэн гарч болохгүй шүү хэмээн бидэнд захицгааж байлаа. Бид гурав наранд түлэгдэхгүй гэж дотуур цагаан цамцтайгаа далайн бүлээн сайхан усанд орж билээ. Орой нь Джакарта руу буцаж нисэх үед бүх биеийн арьс улайж, халуун оргин хорсох нь тэсэхүйеэ бэрх болж билээ.

Ийнхүү түг түмэн арал бүхий Индонези оронд хийсэн айлчлал маань өндөрлөж билээ.

Жакартаас Сингапурт буулаа.

Малаккийн хоолойн өмнөхөн үзүүрт орших Сингапур арал дээр Сингапур нийслэлтэй Сингапур улс тусгаар тогтнолоо олж 1965 онд НҮБ-д гишүүнээр элсэн ороод эдүгээ Азийн бар болсон нэгэн улс юм.

Монгол улс Сингапур улстай 1970 онд дипломат харилцаа тогтоосон билээ. Тэр улсад айлчилсан монголын албан ёсны анхны төлөөлөгчид нь бидний гурван нөхөд байжээ.

Гоо үзэсгэлэнтэй өндрөөс өндөр «Шингрила» хэмээх зочид буудалд биднийг зочны хувьд үнэ хөлсгүй байрлуулав. Манай улсын сайн санааны төлөөлөгчдийг Сингапурын Гадаад явдлын яамны сайд Раджаратнам элэгсэг найртай хүлээн авч ярилцав. Ноён сайд улс орныхоо хөгжил дэвшлийн тухай дэлгэрэнгүй ярихын хамт Монгол улсын тухай ихэд сонирхон асууж ярилцсан билээ. Гадаад бодлого, олон улсын харилцааны тухай ярихдаа Европынхон сүүлийн 200 жилийн турш Азийн өмнөөс үг хэлж биднийг төлөөлдөг байсан бол эдүгээ бид Азийнхаа өмнөөс өөрсдөө үг хэлж ярьдаг болов. Улс түмний энх тайван, аюулгүй байдлыг тогтоохын тул нэгд: их гүрнүүд хоорондоо мөргөлдөн тэмцэлдэхгүй байх; хоёрт: их гүрнүүд бага жижиг улс орны дотоод хэрэгт оролцохгүй байх; гуравт: бага жижиг улс орон хоорондоо мөргөлдөн тэмцэлдэхгүй байж, дотоодын хөгжил дэвшлийнхээ асуудалд эн тэргүүн анхаарч байх нь чухал байна гэж тэрээр цохон тэмдэглэж билээ.

Сүрлэг өндөр байшин барилгатай, цэмцгэр цэвэрхэн бөгөөд үзэсгэлэнт байгальтай энэ жижиг арлын улс- хотод хэдхэн хоног айлчлахад хөгжлийн эрч хүч нь хурдан түргэн, хүн ам ажилч хичээнгүй болох нь албан газар, пүүс, компанийн хүмүүстэй уулзаж ярилцсан үед ил тодхон байж билээ.

Сингапурын бизнесменүүд монголын экспортын барааны төрөл, тоо хэмжээ, бололцооны талаар асууж лавлах нь байсан боловч бидний зүгээс тэдэнд тодорхой хэлэх юм тэр үед байгаагүй нь ойлгомжтой биз ээ. Харин эдүгээ цагт Сингапурын элдэв барааг импортлож байгаа нь нэг талаар хувийн арилжаа наймаанд өгөөжтэй байж болох авч улс хоорондын харилцан ашигтай эдийн засаг, худалдааны түншлэлийн хувьд ахицгүй байгаа нь харамсалтай гэж бодном.

Сингапураас Малайзийн нийслэл Куала-Лумпурт хүрэлцэн очлоо.

Малайзийн засгийн газар Зүүн өмнөд Азийг төвийг сахисан бүс нутаг болгох санал дэвшүүлсэн юм. Малайзийн ерөний сайд Тун Абдул Разак манай төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж ярилцсан үед колонийн дарлал, дайн дажинд нэрвэгдэж байсан энэ бүс нутгийн амар амгалан, аюулгүй байдлыг тогтвортой болгох, хөгжил дэвшлийн зорилгод энэ санал санаачилга бүрэн нийцэж байгаа юм аа гэж Онцлон тэмдэглээд их гүрнүүд бусад улс орны дотоод хэрэгт оролцохгүй байх явдал юу юунаас ч чухал байна. Гэхдээ өндөр хөгжилтэй улс орны дэмжлэгтэйгээр бид цэцэглэн мандах учиртай гэж ярьж байлаа.

Бидний айлчлалын үед «Зүүн өмнөд Азийг төвийг сахисан бүс нутаг болгох саналыг Монгол улс дэмжиж байна» гэсэн гарчигтай өгүүллийг төвийн нэгэн сонинд нийтэлсэн билээ.

Газрын эрдэс баялагаар элбэг энэ орон цагаан тугалга боловсруулан гадагш гаргаж их ашиг олдог юм. Бидэнд тийм нэгэн үйлдвэр үзүүлж билээ.

Бидний айлчилсан энэ гурван улс эрт дээр үеэс түүх соёл, Хэл шашны уламжлалт хэлхээ холбоотой, тэнгис далайд хүчирхэг улс гүрний колонийн дарлалд олон жил талхигдаж байсан юм. Хятад, Энэтхэг болон аравын орнуудын нөлөө их байсан, хүн ам нь шашин шүтлэг, соёл, хэл бичгийн өвийг хадгалж үлдсэн нь арвин болой.Өнгөрсөн дайны хөлд багагүй нэрвэгдсэн эдүгээ өрнөдийн өндөр хөгжилтэй улс орны дэмжлэгтэйгээр тэргүүний техник технологи нэвтрүүлж, өөрсдийн хүчин зүтгэлийн ачаар бага буурай

орны дүр төрхийг халж хөгжингүй орон болох замд их амжилт олж явна.

Дараа жил 1974 оны гуравдугаар сарын сүүлчээр Шри-Ланкийн нийслэл Коломбод АНДЭЗНК-ын ХХХ чуулган болж элчин сайд Б. Дашцэрэн, Д.Чулуундорж бид гурав оролцсон юм. Энэ албатай хослуулан уг чуулганыг хуралдаж дууссаны дараа бид гурав манай ГЯЯ-ны төлөөлөгчдийн хувьд Шри-Ланка, Энэтхэг, Бангладешид албан ажлын айлчлал хийсэн юм.

Шри-Ланкийн ГЯЯ-ны орлогч сайд Жаякодитай уулзаж ярилцав. Тэрээр хэлэхдээ манай орон сайн чанарын цай үйлдвэрлэж гадагш гаргадаг. Танай орноос улаан буудайг Оросоор дамжуулан авч болох юм гэж бодож байна. Бас бусад барааг ч харилцан солилцож болох юм гэж яриу. Соёлын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулах тухай санал тавьж бид төслийг нь өгсөн юм. Манай энэ саналыг талархалтай хүлээн авч ойрын хугацаанд хэрэгжүүлэх бодолтой байгаагаа нотлов.

Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгох тухай Шри Ланкийн саналыг Монгол улс бүрэн дэмжиж байгааг бид нотолсон юм.

Тус бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комиссын ээлжит чуулганы үр дүн, хоёр улсын гадаад дотоод бодлого, тивийн улс орны нийтлэг асуудлаар санал бодлоо солилцож, байр сууриа харилцан илэрхийлсэн хоёр талын энэ уулзалт яриа үр ашигтай болсон. Шри Ланкийн ГЯЯ-нд болсон уулзалт дээр ерөнхий сайд С.Бандаранайкад явуулсан Ю.Цэдэнбалын илгээлтийг гардуулан өгч цааш нь дамжуулан хүргэхийг бид хүссэн юм. Шри-Ланкийн коммунист намын удирдах нөхөд намынхаа төв байранд биднийг хүлээн авч уулзан элэгсэг дотно ярилцаж, хоёр орны найрамдлын үдэшлэг зохион байгуулж билээ.

Энэтхэгийн далайн эрэг дээр орших Коломбо хотын түүх, соёлын дурсгалт газар сонирхон үзэж, хотоос хойшхон буй ой модоор бүрхсэн өндөрлөг газрын сэрүүвтэр байгаль орчноор тойрон аялж явлаа.

Дэлхийн эртний улс орны нэгэн бөгөөд өв соёлын буурал түүхтэй орон Энэтхэгт дахин айлчлах азтай завшаан тохиолдов.

Бид хэдэн хоног тавтай айлчилсан орон-Шри-Ланкийн Коломбоос нисч дөрөвдүгээр сарын 13-нд Бомбейд буув. Энэтхэгийн ГЯЯ манай төлөөлөгчдийн айлчлалыг энэ хотоос эхлүүлэхээр хөтөлбөр зохиосон байв.

Аравийн тэнгисийн эрэг орчим буй энэтхэгийн эртний алдарт түүх дурсгалын газар луу моторт жижиг усан онгоц хөлөглөж нэг бүтэн өдөр аялав.

Шинэ Дели хотод ГЯЯ-ны нарийн бичгийн дарга В.С.Триведитэй яриа хэлэлцээ хийв. Хоёр улсын уламжлалт сайн харилцаа, дотоод амьдралын өнөөгийн байдал төлөв, тив нутгийн сонирхож буй асуудлаар санал солилцож, харилцан мэдээлэв.

Хоёр өдөр үргэлжилсэн энэ яриа хэлэлцээн дээр энэтхэгийн тал эвслэд үл нэгдэх хөдөлгөөн, зэвсэг хураах асуудал, салбар бүс нутгийн байдал, хөгжиж буй улс орны бэрхшээл, эрчим хүч, газрын тос шатахууны үнийн өсөлт зэрэг асуудалд түлхүү анхаарч дэлгэрэнгүй ярив. Мөн монгол-Энэтхэгийн худалдааны харилцааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлж байлаа.

Дөрөвдүгээр сарын 19-ний өдөр Энэтхэгийн ерөнхий сайд Индира Ганди Парламентын ордонд биднийг найрсаг хүлээн авч элэгсэг дотно ярилцсан билээ.

Манай төрийн тэргүүний халуун мэндчилгээг уламжлан Индира Ганди Монгол Улсад айлчлах урилгатайг дурдан ярихад Монгол оронд айлчлан очихыг үргэлж санаж бодож явдаг. Монголын төлөөлөгчид манай оронд айлчлан ирсэнд баяртай байна. Ю.Цэдэнбалд миний чин сэтгэлийн мэндчилгээ хүргэж байгааг уламжлахыг Та бүхнээс хүсье гээд монгол-Хятадын харилцааны тухай сонирхон асууж байлаа.

Энэтхэг анд нөхөд Азийн хамтын аюулгүйн систем байгуулах асуудлыг авч үзэхдээ олон улсын намжмал байдлыг гүнзгийрүүлэхийн чухлыг онцлон өгүүлэхийн хамт тэр үеийн ЗХУ, бусад социалист орнуудтай тал бүрийн харилцааг хөгжүүлэхийг эрхэмлэдэг бөгөөд Ази тивийн байдал Европынхтой адилгүй, Зүүн өмнөд Азид болон Ойрхи Дорнодод Зэвсэгт мөргөлдөөн байсаар байгаа, мөн Хятадын оролцоогүйгээр энэ бүс нутагт аюулгүй байдлыг тогтоох боломжгүй байна гэж үздэг хэмээн цохон тэмдэглэж билээ.

Халуун бүгчим өглөө Делигээс Дакка руу хөдлөх нисэх онгоцонд сууж сэрүүцэн явах зуур цонхоор харваас аварга Гималайн нурууны мөнх цаст оргилууд тодхон харагдаж улам ч сэрүүцэх шиг болж билээ. Тэнгэр баганадсан сүрлэг уулс онгоцны цонхоор илхэн зурайсаар удалгүй үүл, манан бүрхэж, онгоц маань аажмаар Бенгалийн булангийн зүг уруудав. Даккийн нисэх онгоцны буудалд

газардахад гадагш гарваас саунад ороод ирсэн юм шиг бүгчим, чийгтэй уур өөдөөс төөнөв.

Бангладешийн гадаад хэргийн нарийн бичгийн дарга Мухамед Ахмед онгоцны буудал дээр биднийг угтан авч билээ.

Маргааш өглөө нь хоёр талын яриа хэлэлцээ болж завсарлав. Монгол Бангладешийн хооронд соёлын талаар хамтран ажиллах Хэлэлцээр байгуулахаар тохиролцоод уг баримт бичгийн монголын талын эх хувийг бэлтгэж гарын үсэг зурав.

Бангладешийн Гадаад явдлын яамны сайд Кемал Хусейн манай төлөөлөгчдийг хүлээн авч уулзан ярилцав. Мөн боловсролын Яам, Хөдөө аж ахуйн яамны сайд нартай уулзуулав.

Хөгжлийн түвшнээр буурай, 75 сая хүн амтай, нутаг дэвсгэр багахан, байгалийн үерийн гамшигт нэрвэгддэг их хөрш Энэтхэгийн дэмжлэг тусламжид түшиглэдэг, олсны ургамал ихээхэн тариалж жүт үйлдвэрлэж экспортлодог, Пакистанаас салж тусгаар улс болсон Бангладешийг хүлээн зөвшөөрсөн эхний орнуудын нэгэн нь Монгол улс мөн хэмээн талархаж байдаг байжээ.

Бид Бангладешийн булангийн ойролцоо орших Читагонг хотод нисэх онгоцоор хүрч далайн боомт, нефть цэвэрлэх үйлдвэр, усан цахилгаан станц зэрэг газраар явж үзлээ.

Маргааш өглөө нь Дакка руу буцаж очтол удалгүй Ерөнхий сайд Мужибур Рахмантай уулзаж ярилцав.

Банглабадкү /үндэстний эцэг/ м.Рахман өөрийн ордонд биднийг маш элэгсэг дотно хүлээн авч ярилцсан. Ю.Цэдэнбалын илгээлтийг түүнд гардуулахад ихэд талархан хүлээж аваад танай улсын эрхэм хүндэт даргад би хариу талархлын илгээлтээ даруйхан явуулна гэж билээ. Дараа нь тэнд төрийн эргэлт болсон үед М.Рахман амь насаа алдсан тухай мэдээ хожим сонсоод үнэмшин ядаж байлаа.

Манай төлөөлөгчид эх орондоо буцаж очоод эдгээр айлчлалын тухай нам, засгийн дээд удирдлагад илтгэж танилцуулахад төлөөлөгчдийн үйл ажиллагааны үр дүн зүйтэй болов хэмээн үнэлэн дүгнэж тусгай тогтоолд тэмдэглэсэн билээ.

Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссын XXXII чуулган 1976 оны гуравдугаар сарын сүүлчээр Бангокт хуралдах болсон тул далимаар Тайланд, Филиппин, Ардчилсан Йеменд манай улсын сайн санааны төлөөлөгчдийг албан ёсоор

айлчлуулах асуудлыг ярилцахад ганцхан Филиппиний талаас л нааштай хариу авч чадаагүй юм.

Миний бие Тайландад 1972 онд очиж дээрх байгууллагын ээлжит чуулганд оролцсон юм. Тэр үед Монгол улс Тайландтай дипломат харилцаагүй байлаа. Хоёр жилийн дараа манай хоёр улс бие биетэйгээ харилцаа тогтоосон байлаа. Тэр үед Тайланд улс Филиппиний нэгэн адил өрнөдийн гүрнүүдийн нөлөөнд хүчтэй орсон хэвээр байсан юм.

Монгол улсын албан ёсны анхны төлөөлөгчид / элчин сайд Б. Дашцэрэн, манай яамны ажилтан Б.Сувд. Д.Хүрэлбаатар нар оролцсон ийнхүү айлчлан очиход биднийг байрлуулсан зочид буудлын гадна талд БНМАУ-ын болон Тайландын төрийн далбааг мандуулсан байлаа.

Тайландын Гадаад хэргийн төрийн нарийн бичгийн даргын орлогч Ананд Панъярачунтай яриа хэлэлцээ хийх үед манай тал Азийн хамтын аюулгүй байдлын систем тогтоох, энэ тивийн улс орны чуулга уулзалт хийх тухай зарим санал санаачилгын талаар тайландын талын бодол санааг тандах, Азийн одоогийн байдал төлөвийг хэрхэн дүгнэж байгааг нь мэдэх зорилготой байсан юм.

Урьд нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганууд дээр надтай уулзалдаж танил болсон А. Панъярачун ярихдаа Ази, Номхон далайн бүс нутгийн улс орны газар зүйн байдал, улс төрийн систем, шашин шүтлэг, хөгжлийн түвшин адилгүй, их гүрнүүдийн ашиг сонирхол энэ тэр бүс нутагт нь халз тулгарч байдаг, гадаадын цэргийн бааз тухтай байрласан, Дэлхийн бусад бүс нутгийг бодвол энэ тивд зэвсэгт мөргөлдөөн олон жилийн турш хамгийн хүчтэй бөгөөд бас их гүрнүүдийн тэтгэлэгтэйгээр гарсаар байгаа болохоор хамтын аюулгүй байдлын систем тогтоох, бүх улс орны оролцоотой чуулга уулзалт хийх нөхцөл бүрэлдтэл нэлээд хугацаа шаардагдана гэж үзэж байлаа.

Ер нь бидний айлчлал хийсэн Азийн орнууд уг асуудлаар ийм адил төстэй үзэл бодолтой байсан нь бодит үнэн байдалд нийцтэй байжээ. Байдал төлөв өнөө хэр нь хэвээр байна.

Монгол улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүнд 1976-1977 онд нэрээ дэвшүүлэх бодолтой байгаа тул дэмжлэг үзүүлэхийг албан ёсоор хүссэн юм. Тайландын тал хариулахдаа энэ асуудал ихээхэн түвэгтэй. Бид боломж гарвал танай саналыг дэмжих талаас нь харж үзнэ. Бидний болгоомжлох нэг зүйл бол Азийн бүлгээс өөр улс орон нэрээ дэвшүүлж магад юм гэж эмээж байна гэсэн билээ. Монгол улс тэр үед НҮБ-ын хүрээнд улс төрийн асуудлаар Азийн бүлэгтэй нэгдэн ажиллахаас цэрвэж байсан

явдал энэ сонгуульд амжилт олоход саад бэрхшээл болсон юм аа. Бас тэгээд Пакистан нэрээ дэвшүүлж нийт бүлгийн дэмжлэг авах бүрэн найдлагатай болсон нь сүүлд тодорхой болов.

Бид Монгол улсын төрийн тэргүүнээс Тайландын Цог жавхлант Ван Пүмипон Адулядет-т өргөн барьсан илгээлтийг гардуулах даалгавартай яваагаа айлтгахад хаантан Банкокт эзгүй байсан тул хааны зөвлөх ноён Чарун Исрангхунд бараалхаж уг илгээлтийг дамжуулав.

Харин АНДЭЗНК-ын чуулганы үед гишүүн улс орны төлөөлөгчдийн тэргүүн нарыг Тайландын хаан хүлээн авч уулзан аяга цайгаар дайлахад голын дугуй ширээнд хааны ойролцоо сууж хэдэн үг солих завшаан олдсон юм. Ю.Цэдэнбалын илгээлтийн тухай дурдвал «Монгол улс манайхаас алс хол оршдог боловч тэр алсаас манай ард түмэн үүсэл гаралтай гэж бидний өвөг дээдэс ярьж байсан юм» хэмээн хэлээд «танай ноён Ерөнхийлөгчид миний бие хариу илгээлт явуулна» гэж билээ. Тэгээд мөн оны зургадугаар сарын 16-нд Улаанбаатарт ирүүлсэн илгээлтдээ «танай ГЯЯ-ны орлогч сайд Д.Эрдэмбилэгээр уламжлан ирүүлсэн Таны илгээлтэд чин сэтгэлээс талархаж байгаагаа илэрхийлье. Манай хоёр улс газар нутаг, зам харилцааны хувьд бие биенээсээ алслагдсан боловч арьс өнгө нэгтэй, Азийн улс үндэстний хувьд ойр дотно холбоотой байдаг юм» гэж өгүүлсэн нь буй.

Дээрх байгууллагын чуулганы үед тайландын Ерөнхий сайд К.Прамотт, ГЯЯ-ны сайд Ч.Чунхаван нартай уулзаж ярилцах үед монголын сайн санааны төлөөлөгчид Тайландад анх удаа айлчлан ирсэнд баяр хүргэж, эрт дээр үеэс түүхийн холбоотой манай хоёр орны харилцааг хөгжүүлэх, худалдаа хийх, тухайлбал Тайландын тал сайн чанарын цагаан будаа Монголд нийлүүлж болох, гадаад харилцааны байгууллагуудын хооронд хэлхээ холбоотой байх тухай цохон тэмдэглэж байлаа. Бид Бангокт Хааны их ордон, Буддийн сүм үзэж, Хааны хүндэт зочны дэвтэрт монгол бичгээр гарын үсэг зурж дурсган үлдээсэн билээ.

Бидний энэ сайн санааны айлчлалын дараа миний бие Бангкокоос Ардчилсан Иемений нийслэл Аден руу нисч хүрлээ. Тэнд элчин сайд Ц.Дэмиддагва, Агваандамдин хоёр Кайраас хүрэлцэн ирээд байлаа. Араб ертөнцөд эртний түүхийн өв уламжлалтай Йемений хаант улс стратегийн чухал байршилтай учир Турк, Английн эрхшээлд олон жил байжээ.

Дайны дараа тусгаар тогтносон улс болсон боловч хоёр хэсэгт хуваагдан Өмнөд Йеменд ардчилсан засаг тогтож хуучин ЗХУ болон

зарим социалист орнуудтай найрсаг харилцаатай болж энэ бүс районд социалист чиг баримжаатай гэгдэж байсан орны нэг болоод байсан юм.

Бид Аденд айлчилсан үедээ ГЯЯ-ны сайд, орлогч сайд нартай уулзаж, хоёр талын сонирхож байсан асуудлаар санал бодлоо солилцож билээ. Тэр үед төрийн тэргүүн нь биднийг хүлээн авч уулзаж ярилцах үед бид Ю.Цэдэнбалын илгээлтийг гардуулсан билээ. Хэдэн жилийн дараа Аденд төрийн эргэлт болж, зарим удирдагчид нь амь насаа алдаж, хойд өмнөд хэсэг дахин нэгдэн нэгэн улс болсон түүхтэй.

Азийн чиглэлд хийсэн урт замын аялал айлчлал маань ийнхүү өндөрлөв.

Монгол улсын засгийн газар Ази тив рүү чиглэсэн гадаад бодлого явуулж эхэлсэн нь зүйн хэрэг. Энэ бодлогод оносон алдсан алхам бий. Нээлттэй гадаад бодлого явуулж байгаа эдүгээ үед тив нутгийн улс төрийн бодит байдалд тулгуурлан улс орныхоо хөгжлийн ирээдүйн төлөвийг зөв мэргэн тодорхойлж, Монгол улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг хөдөлшгүй баталгаажуулсаар монголын ард түмний язгуур эрх ашгийг цаашид гуйвалтгүй хамгаалж байх эрхэм дээд зорилго манай ардчилсан төр, засгийн өмнө үеийн үед байсаар байх болно гэдэгт гүнээ итгэнэм.

Ийнхүү итгэхийн учир гэвэл өмнөх төрийн тогтолцооны он жилүүдэд манай гадаад дотоод бодлого гадаад хүчин зүйлээс ихэд шалтгаалж байсан бол өнөөдрийн Монгол улсын Ази болон даян Дэлхийд эзлэвэл зохих байр сууриа баттай олж, монголын ард түмэн хувь заяаныхаа эзэн болж цэнглийн манлайд хүрэх нь мэргэн ухаан, хүчин зүтгэлээс нь шууд хамаарах болсонтой холбоотой.

Азийн хөгжилтэй улс орны түвшинд хүрэхийн тулд хамтран зүтгэх бүс нутгийн тэр улс орон, ард түмний нь ахуй амьдралыг ойр танин мэдэх, бас өөрсдөө ахуй амьдралын өндөр соёлыг эзэмших, нарийн дэг журамтай, тэсвэр хатуужилтай, ажилч хичээнгүй байдлыг туйлын эрхэмлэсэн залуу үеийг төлөвшүүлэх нь чухал юм. Энэ бүхэн төрийн жолоог атгалцаж, гадаад харилцааны алба хашиж яваа нөхдийн сэтгэл зүрхнээс уяатай байх эрхэм зүйл мөн гэлтэй.